Н.Нямдаваагийн нэрэмжит
Хавдар судлалын үндэсний төв

# ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН



# ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛГО:** Хавдрын тусламж үйлчилгээнд шинэ дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлж, үйлчлүүлэгч төвтэй чанартай тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үзүүлэх замаар хорт хавдрын шалтгаант нас баралтыг бууруулж, хавдраар өвчлөгсдийн амьдралын чанарыг сайжруулах | | | | | | |
| ЗОРИЛТ 1: ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДААС ТУСГАЙЛАН ҮҮРЭГ БОЛГОСОН АРГА ХЭМЖЭЭГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛНЭ. | | | | | | |
| 1. | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/370 дугаар тушаал: Тархи нугасны хавдрууд, толгой хүзүүний байрлалтай хавдрын үеийн стереотактик туяа эмчилгээ нэвтрүүлэх бэлтгэл хангана. | 7.0 сая Евро Австрийн Засгийн газрын зээл | - Суурилуулж тохируулга хийгдсэн шугаман хурдасгуур аппарат<br>- Батлагдсан эмчилгээний протокол | Аппарат суурилуулах бункерын засвар хийгдсэн.<br>Тоног төхөөрөмжийн худалдан авалт хийгдсэн. | - Туяа эмчилгээний шугаман хурдасгуур аппарат суурилуулж,<br>- тохируулга хийгдсэн байна.<br>- Тархи нугасны хавдрууд, толгой хүзүүний байрлалтай хавдрын үеийн стереотактик туяа эмчилгээний протокол<br>- Батлагдсан байна. | - Төслийн хүрээнд туяа эмчилгээний Truebeam шугаман хурдасгуурт аппаратыг суурилуулсан ба цацрагийн хэмжилт, тохируулгыг 2023 оны 12 сард хийж дуусгахаар ажиллаж байна.<br>- Туяа эмчилгээ, тархины мэс засал болон дүрс оношилгооны эмч нараас бүрдсэн олон мэргэжилтний баг БНХАУ-ын Тайваньд 2022 оны 12 сараас 2023 оны 02 сар хүртэл дадлагажих сургалтад хамрагдсан.<br>- 2024 оны эхний улиралд багтаан, 5 мэргэжилтнийг урт хугацааны сургалтанд хамруулах бэлтгэл ажил бүрэн хангагдсан.<br>- Тархи нугасны хавдрууд, толгой хүзүүний байрлалтай хавдрын үеийн стереотактик туяа эмчилгээний протоколыг дотоодын мэргэжилтэний баг боловсруулсан ба ОУАЭА-ийн шинжээчийн багт санал, зөвлөмж авахаар илгээсэн.<br>- Гүйцэтгэл- 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Батлагдсан байна. | - эмчилгээний протоколыг дотоодын мэргэжилтэний баг боловсруулсан ба ОУАЭА-ийн шинжээчийн багт санал, зөвлөмж авахаар илгээсэн.<br>- Гүйцэтгэл- 100% |
| 2. | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/370 дугаар тушаал: Цагаан мөгөөрсөн хоолойн хавдрын мэс засал эмчилгээг нэвтрүүлнэ. | 5.0 Эрүүл мэндийн даатгалын сан | Амжилттай хийсэн мэс заслын тоо | 2021 онд нэг тохиолдолд мэс засал эмчилгээ хийж байсан. | Цагаан мөгөөрсөн хоолойн хавдрын мэс засал эмчилгээг 1-ээс цөөнгүй тохиолдолд хийнэ. | Хийсэн мэс заслын тоо – 0<br><br>Энэ онд Цагаан мөгөөрсөн хоолойн хорт хавдрын тохиолдол бүртгэгдээгүй.<br><br>Гүйцэтгэл- Тооцох боломжгүй. |
| 3. | Монгол улсад хийгдэхгүй байгаа түвөнх-залгиурын мэс заслын дараах сайжруулсан нөхөн сэргээлтийн (enhanced recovery after surgery-ERAS) технологийг нэвтрүүлнэ. | 40.0 Эрүүл мэндийн даатгалын сан | – Батлагдсан эмчилгээний протокол<br>– Амжилттай хийсэн мэс заслын тоо | Нэвтрээгүй. | Эмчилгээний протокол батлагдсан байна. Түвөнх-залгиурын мэс заслын дараах сайжруулсан нөхөн сэргээх мэс заслыг 5-аас цөөнгүй тохиолдолд амжилттай хийсэн байна. | Түвөнх-залгиурын мэс заслын дараах сайжруулсан нөхөн сэргээлтийн (enhanced recovery after surgery-ERAS) протоколыг шинээр боловсруулсан ба ХСҮТ-ийн Эмнэл зүйн хорооны хурлаар хэлэлцүүлж батлуулсан.<br><br>Гүйцэтгэл-100%. |
| 4. | Түвөнхийн дурангийн мэс заслыг нэвтрүүлнэ. | 10.0 Эрүүл мэндийн | Түвөнхийн нийт мэс заслын дотор эзлэх хувь | Нэвтрээгүй. | Түвөнхийн нийт мэс заслын 10 ба түүнээс цөөнгүй хувийг дурангийн | Түвөнхийн 20 мэс засал хийснээс 17 буюу 85 хувьд дурангийн мэс заслыг амжилттай хийсэн. |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | даатгалын сан | | | аргаар хийсэн байна. | Гүйцэтгэл-100% |
| 5. | Ам залгиурын хорт хавдрын оношилгоонд хүний папиллома вирус (ХПВ) илрүүлэх шинжилгээг хийнэ. | 10.0<br><br>Эрүүл мэндийн даатгалын сан | Шинжилгээ хийсэн тохиолдлын хувь | 20 тохиолдолд судалгааны зорилгоор ХПВ илрүүлэх шинжилгээ хийсэн. | Ам залгиурын хорт хавдраар оношлогдсон нийт эмчлүүлэгчдийн ≥20%-д ХПВ илрүүлэх шинжилгээ хийсэн байна. | Ам залгиурын хорт хавдартай нийт 18 тохиолдлын 16 буюу 89 хувьд ХПВ илрүүлэх шинжилгээг хийсэн. 2 тохиолдол нь хувийн эмнэлгийн баталгаажсан шинжилгээний дүгнэлттэй байсан тул хийгээгүй.<br><br>Гүйцэтгэл-100%. |
| 6. | Туяа эмчилгээний төлөвлөлтөд хиймэл оюун ухаан (AI) ашиглаж эхэлнэ. | - | Туяа эмчилгээний төлөвлөлтөд хиймэл оюун ухаан (AI) ашигласан өвчтөний хувь | ОУАЭА-ийн төслөөр Velocity програм авсан. | Туяа эмчилгээний төлөвлөлт хийлгэсэн өвчтөний 20-оос доошгүй хувьд хиймэл оюун ухаан (AI) ашигласан байна. | – АНУ–ын Вашингтоны Их Сургуулийн Эмнэлгийн 2022 оноос хэрэгжүүлж буй "Туяа эмчилгээний салбарт хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх нь" төсөлд хамрагдан, туяа эмчилгээний төлөвлөлтөд эрсдэл бүхий эрүүл эд эрхтэнийг хиймэл оюун ухаан ашиглан дүрслэх ажил 100% хийгдэж байна.<br>– Туяа эмчилгээний төлөвлөлтийн Velocity программ нь хиймэл оюун ухааны функц ашиглан, өвчтөний хийлгэсэн PET/CT болон MRI оношилгооны мэдээллийг туяа эмчилгээний төлөвлөлтийн системд Deformable байдлаар холбох чадвартай бөгөөд өвчтөний эмчилгээнд бай ээлэхүүнийг болон |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрсдэл бүхий эрүүл эд эрхтэн дүрслэхэд өндөр ач холбогдолтой.<br><br>Гүйцэтгэл- 100% |
| 7. | Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний журмыг шинэчлэн боловсруулна. | 4.0<br><br>Эрүүл мэндийн даатгалын сан | Шинэчлэн боловсруулсан заавар/ удирдамжийн тоо | Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний нөхцөл байдлын үнэлгээгээр журмыг шинэчлэх зөвлөмж өгсөн. | "Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ үзүүлэх журам"-ыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн яаманд саналаа хүргүүлсэн байна. | Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний дараах бодлогын баримт бичгийг шинэчилсэн. Үүнд:<br>**Журам:** Эрүүл мэнд спортын сайдын 2015 оны 329 дүгээр тушаалаар батлагдсан "Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний журам"-ыг шинэчлэн боловсруулж, ЭМЯ-ны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газарт 2023.09.15-нд хүргүүлсэн.<br>**Заавар:** "Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний заавар"-ыг дараах 2 агуулгаар шинээр боловсруулж, нэгтгэсэн. Үүнд:<br>- Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний сувилахуйн заавар,<br>- Хөнгөвчлөх эмчилгээний эмнэлзүйн заавар<br>Эмнэлзүйн зааврыг 2023 оны 12 сарын 13-нд ХСҮТ-ийн Эмнэлзүйн салбар хорооны хурлаар хэлэлцүүлэгдэнэ.<br>2023.12.19-нд ЭМЯ-нд болох "Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний эмч, сувилагч нарын зөвлөлдөх уулзалт"-ад эцэслэн хэлцэгдэхээр бэлтгэл ажил хангагдсан.<br>Гүйцэтгэл 100%. |
| 8. | Шаардлагатай стандартуудыг | 4.0 | Шинээр боловсруулсан | 2005 онд | -Хавдрын тусламж үйлчилгээ үзүүлэх | Хавдрын тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор 2023 онд дараах |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| 9. | шинээр болон шинэчлэн боловсруулж эрх бүхий байгууллагад хүргүүлнэ. | Эрүүл мэндийн даатгалын сан | стандартын төслийн тоо | Хавдрын тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандарт батлагдаж байсан. | байгууллагын бүтэц, үйл ажиллагаа стандарт, -Хавдрын түгээмэл үйлдлийн стандартыг шинэчлэн боловсруулж, төслийг эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна. | эмнэл зүйн 46 заавар, стандартыг шинэчилэн боловсруулсан. Үүнд:<br>- Эмнэлзүйн заавар (3).<br>- Түгээмэл үйлдлийн стандарт (43)<br>Ингэснээр хавдрын тусламж үйлчилгээнд мөрдөх 87 төрлийн эмнэл зүйн заавар болон стандартыг шинэчилэн, ЭМЯ болон Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлээд байна.<br>Гүйцэтгэл-100% |
| 10. | Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлнэ. | 10.0<br>Эрүүл мэндийн даатгалын сан | - Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь<br>- Ёс зүйн зөрчлийн тоо | Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн салбар хорооны төлөвлөгөөг жил бүр батлан хэрэгжүүлдэг. | Төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.<br>Ёс зүйн зөрчлийн тоо өмнөх оныхоос буурсан байна. | Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор 2023 онд 4 үйл ажиллагааг 100% хэрэгжүүлсэн. Ажилтан хоорондын харилцаатай холбоотой ёс зүйн 1 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй ижил байсан. Үүнд дүгнэлт хийж мэргэжлийн байгууллагуудтай хамтран, цуврал сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар хувь хүний сэтгэл зүйн онцлог, харилцааны ур чадвараа дээшлүүлэх боломж, өөрт тулгарч байгаа асуудлаа зөв тодорхойлох, түүнийг даван туулах аргуудын талаар сайн жишээг харуулсан сонирхолтой илтгэл тавигдсан нь үр дүнтэй байсан. (Хавсралт 1: Ёс зүйн |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан)<br>Гүйцэтгэл-100% |
| 11. | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлнэ. | 3.0<br>Эрүүл мэндийн даатгалын сан | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Авилгаас сэргийлэх хөтөлбөрийг жил бүр батлан хэрэгжүүлдэг. | Төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор 16 үйл ажиллагааг төлөвлөн, 100 хувь хэрэгжүүллээ.<br>Хавсралт 2: Авлигаас сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан<br>Гүйцэтгэл-100% |
| 12. | Байгууллагын үйлчилгээний соёлын заавар/ удирдамжийг батлуулан мөрдүүлнэ. | 100.0<br><br>Эрүүл мэндийн даатгалын сан | - Батлагдсан заавар/ удирдамж<br>- Байгууллагын үйлчилгээний соёлтой холбоотой гомдлын шийдвэрлэлт | 2018 онд төвийн Branding book батлан мөрдөж байна. Үйлчилгээний соёлтой холбоотой гомдлыг тусад нь бүртгэдэггүй. | Байгууллагын үйлчилгээний соёлын заавар/ удирдамжийг шинэчлэн баталж мөрдсөн байна. Байгууллагын үйлчилгээний соёлтой холбоотой гомдлыг бүртгэж, бүрэн шийдвэрлэсэн байна. | Байгууллагын соёл, үйлчилгээний журмыг баталж, мөрдөн ажиллаж байна. Журмыг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн.<br>Хавсралт 3: Байгууллагын соёл, үйлчилгээний журмыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний тайлан<br>Гүйцэтгэл-100% |
| **ЗОРИЛТ 2: ХОРТ ХАВДРЫН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ТОГТОЛЦООНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ** | | | | | | |
| 1. | Хавдрын эрсдэлт хүчин зүйлс, урьдчилан | 5.0<br>Эрүүл мэндийн | - Төлөвлөсөн арга хэмжээний | Жил бүр мэдээлэл сурталчилгааны | Төлөвлөсөн арга хэмжээг 90%-иас доошгүй | Олон нийтэд зориулсан мэдээлэл сурталчилгааны ажлын төлөвлөгөөг батлуулан 100% хэрэгжүүлсэн. |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлэлт, эрт илрүүлгийн чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлнэ. | даатгалын сан | хэрэгжилтийн хувь<br><br>- Хандалтын тоо | ажлын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлдэг. Байгууллагын нүүр хуудасны хандалтын тоо 50 000 байсан. | хэрэгжүүлсэн байна.<br><br>Хандалтын тоо 66000 болж өмнөх оныхоос нэмэгдсэн байна. | **Мэдээлэл сурталчилгааны материал:**<br>- "Хорт хавдрын мэдээллийн сар"-ын хүрээнд "live" нэвтрүүлэг (7),<br>- Санамж (6 төрлийн 3000ш)<br>- "Хүнд өвчтөний гэрийн асаргаа, сувилгаа" гарын авлага (500ш),<br>- Хавдрын мэдээллийн саруудын хуанли постер (500ш)<br>- Хавдрын эсрэг Дэлхийн өдөрт зориулан "Дуу хоолойгоо нэгтгэе-үйлдэл хийе" 60 секундын видео шторк,<br>- Төвийн пэйж, веб хуудсаар постер мэдээлэл (11),<br>- Видео ярилцлага 2 эмч,<br>**Сургалт:** нийт 978 хүнд сургалт зохион байгуулсан.<br>- ЦДБЭЧ-ын 100 алба хаагч,<br>- Байгалийн түүхийн музейн 50, ЗГХЭГ-ын 60,<br>- Тайванийн ГБХД сантай хамтран эмзэг бүлгийн өрхийн 100,<br>- ЕБС-ийн сургуулийн 428 сурагч, ба 240 эцэг эх,<br>- Хавдрын даван туулагч 80,<br>**Сайн дурын идэвхтэн:** ХААН банкны Увс, Дорнод аймгийн салбарын 25 ажилтанг бэлтгэсэн.<br>**Арга хэмжээг** хамтран зохион байгуулсан. Үүнд: |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - "Эрүүл монгол хүн" арга хэмжээний үеэр 100 гаруй хүнд үзлэг, зөвлөгөө, мэдээлэл хүргэсэн.<br>- "ЯГААН АЛХАЛТ" арга хэмжээнд төвийн 100 гаруй ажилтан оролцсон.<br>Хавсралт 4: Олон нийтэд зориулсан мэдээлэл сурталчилгааны ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан<br>Гүйцэтгэл 100% |
| 2. | "Хавдрын эсрэг үндэсний аян"-ыг 4 аймагт зохион байгуулна. | 100,0 Хаан банк сан | - Үзлэгт хамрагдсан хүний тоо<br>- Шинээр илэрсэн тохиолдлыг лавлагаа тусламж үйлчилгээнд хамруулсан тоо<br>- Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэний тоо | 2012-2019 онд "Хаан банк сан"-тай хамтран хэрэгжүүлсэн. Жилд дундажаар 20-30 хавдрын шинэ тохиолдол илэрч байсан. Нэг аймагт 100-200 эмч мэргэжилтэнийг сургалтад хамруулж байсан. | Хавдрын эсрэг аяны хүрээнд 3000-аас цөөнгүй хүнийг үзлэгт хамруулж, илэрсэн хавдрын бүх тохиолдолд лавлагаа шатлалын тусламж үзүүлсэн байна. Аймаг, өрх, сумын 500-аас доошгүй эмч мэргэжилтэнийг сургалтад хамруулсан байна. | Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрсдэлт бүлгийн хүн амыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд хамруулах, эрт үед нь оношилж, эмчлэх, орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж чадавхижуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор "Хавдрын эсрэг үндэсний аян-2023"-ыг 4 аймагт зохион байгууллаа. Энэ хүрээнд:<br>- Дорнод, Увс, Завхан (Тосонцэнгэл сум), Өмнөговь аймгийн нийт 5007 хүнд хавдрын эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд хамруулж, хорт хавдрын 62 шинэ тохиолдол илрүүлэн, лавлагаа шатны тусламж үйлчилгээ үзүүллээ.<br>- Говийн бүсийн зөвлөгөөнийг Өмнөговь аймагт 2023.05.19-ны өдөр зохион байгуулж, Дорноговь, Говьсүмбэр, Дундговь аймгийн ЗДТГ, ЭМГ, БОЭТ, НЭ-ийн удирдах ажилтан болон хавдрын мэргэжилтэн зэрэг 72 хүн |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оролцлоо. Зөвлөгөөний үеэр хавдрын цогц тусламж үйлчилгээг хөгжүүлэх талаар илтгэл хэлэлцүүлж, оролцогчид өөрийн аймагт хэрэгжүүлсэн сайн туршлагаа хуваалцсан. Мөн энэ үеэр говийн 4 аймгийн хавдрын цогц тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхийг бэхжүүлэх зорилгоор хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.<br>– Баруун бүсийн зөвлөгөөнийг 2023.06.23-ны өдөр Увс аймагт зохион байгуулж, Завхан, Ховд, Баян-Өлгий аймгуудаас 68 төлөөлөл оролцлоо.<br>- Хими хийдэггүй байсан аймгууд амлалт авсан. Өмнөговь 2023 оны 07 сараас эхлэн хими эмчилгээ эхлүүлсэн<br>- "Хорт хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг" сэдэвт 1 багц цагийн сургалтыг зохион байгуулж 509 эмч, мэргэжилтэн хамрууллаа.<br>- Гүйцэтгэл 100% |
| 3. | Хүний папиллома вирус (ХПВ) илрүүлэх шинжилгээг умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт нэвтрүүлэх бэлтгэл хангана. | 64,0 ДЭМБ | - Шинжилгээний өртгийн тооцоо<br>- ЭМДҮЗ-д гаргасан хүсэлт | 2019 онд 6 дүүрэгт туршилт судалгаа хийгдсэн.<br>6 аймаг, 4 дүүрэг сургалт хийгдсэн. | Шинжилгээний өртгийн болон хэрэгцээний тооцоо судалгааг хийж, ЭМЯ-д хүргүүлсэн байна<br>Шинжилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах талаар | – Умайн хүзүүний хорт хавдар (УХХХ)-ын эрт илрүүлэгт Хүний папиллома вирус (ХПВ) илрүүлэх шинжилгээг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах зорилгоор ЭМЯ, ЭМДГ-т 2023 оны 01 сарын 10 өдрийн 01/41 тоот албан тоотоор уг шинжилгээг нэвтрүүлэх хүсэлтийг тус тус хүргүүлсэн.<br>– 2023 оны 07 сарын 30 өдөр ЭМЯ-ны Санхүү эдийн засгийн албанд хүргүүлсэн. |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүүжилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ЭМДҮЗ-д хүсэлт хүргүүлсэн байна. | – ЭМДҮЗ-ийн шинэчилсэн тушаалд вирус (ХПВ) илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийгдэх тусламж үйлчилгээний багцад оруулан баталсан.<br>– ХПВ-ын халдвар илрүүлэх шинжилгээг эмэгтэй өөрөө өөрөөсөө авах боломжтой эсэхийг турших, цаашид УХХХ-ын эрт илрүүлэгт хэрэглэгдэх боломжийг судлах зорилготой туршилт судалгааг 2023 оны 6-8 саруудад хийж гүйцэтгэсэн. ХПВ-ын халдвар илрүүлэх шинжилгээний 345 эмэгтэй өөрөө өөрөөсөө сорьц авах, мөн тооны эмч мэргэжилтнээр сорьц авхуулж нийт 690 сорьцыг цуглуулж careHPV test аппарат ашиглан хийсэн. Хоёр бүлгийн шинжилгээний хариуны давхцал 95.6%, эмэгтэйчүүдийн өөрөө өөрөөсөө авсан шинжилгээний мэдрэг чанар 72%, өвөрмөц чанар 99%-тай тдорхойлогдсон. Эмч мэргэжилтэн, эмэгтэй өөрөө өөрөөсөө шинжилгээний авах нь нийцэл "сайн." ($p < 0.01$) гэсэн үр дүн гарсан.<br>– ЭМС-ын 2020 онд баталсан "Умайн хүзүүний хорт хавдрын цогц хяналтын заавар"-ын танилцуулах, ажлын байрны дагалдан сургалтыг аймаг, дүүргийн 195 эмнэлгийн мэргэжилтэнд хийсэн. Ингэснээр 2021 оноос хойш 10 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аймаг, 9 дүүргийн нийт 643 эмч мэргэжилтэн энэ чиглэлээр чадавхижаад байна.<br>– ЭМД-ийн 08 тогтоолын шинэчлэлд оруулахаар ЭМЯ-ны НЭМГ-т хүргүүлсэн.<br>– Гүйцэтгэл-100% |
| 4. | "Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээ" байгуулах төслийн хүрээнд холбогдох тоног төхөөрөмжөөр хангана. | 10 сая Евро<br><br>Австрийн Засгийн газрын хөнгөлөлт -тэй зээл | Шинээр суурилуулсан тоног төхөөрөмжөөр хийсэн оношилгооны тоо | ЭМЯ –наас тендер зарлахаар бэлтгэл ажил хийгдэж байна. | Компьютерт томографи, соронзон резонанст томографи, ангиографийн аппарат тус бүр нэгийг суурилуулж, 500-аас доошгүй хүнд оношилгоо, эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. | Бүгд Найрамдах Австри улсын ЗГ, Монгол улсын ЗГ хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх "Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээ" төв байгуулах төслийн гүйцэтгэх ажлын жагсаалтыг 2023 оны 05/02 өдрийн А/163 тоот ЭМСайдын тушаалаар шинэчлэн батлуулсан. Шинэчилсэн тушаалд хавдрын үндэсний сүлжээ төвд-6 нэр төрөл, орон нутгийн хорт хавдрын нэгжид 12 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангахаар баталсан.<br>Худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах тендерийг 2 удаа зарласан ч шаардлага хангаагүйтэй холбоотой цуцлагдсан. 2023 оны 10 сарын 30 өдөр дахин нээлттэй тендер зарлуулан, 11 сарыг 30 өдөр тендерийн нээлт хийж, одоо тендерийн үнэлгээний ажил хийгдэж байна.<br><br>Гүйцэтгэл-70%. |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛТ 3: ХОРТ ХАВДРЫН ЛАВЛАГАА ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ** | | | | | | |
| 1. | ISO 15189:2015 стандартын магадлан итгэмжлэл авах бэлтгэл хангана. | 80.0 Эрүүл мэндийн даатгалын сан | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Бэлтгэл ажил хийгдэж байна. | Төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. | Олон улсын ISO 15189 стандартын баталгаажилтыг хангах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн.<br>ISO 15189:2015 стандартын магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд:<br>- Лабораторийн стандартын шаардлагад нийцсэн агааржуулалт болон барилгын дотор заслын ажлын зургийг хийлгэж, засварын ажлын тендер зарлахад бэлэн болсон.<br>- ISO 15189:2015 стандартад шаардлагатай бичиг баримт боловсруулсан.<br>- Молекул биологийн шинжилгээнд EGFR, BRAF, ALK, ROS1, KRAS, зэрэг хавдрын эсийн генийн мутац илрүүлэх шинжилгээний тоног төхөөрөмжийг бүрэн автоматжуулсан. 2023.08.15-аас Япон, БНСУ, Франц зэрэг улсад үйлдвэрлэсэн молекул биологийн бүрэн автомат тоног төхөөрөмж шинээр суурилуулсан. Ингэснээр нэг сорьцонд 4-5 цагийн дотор 56 эмгэг төрөгчийг оношилох боломжтой болсон. Үүнд:<br>  - **БЗДХ-ын 28 эмгэг төрөгч** (вирус-4, бактери-16, шимэгч-1, мөөгөнцөр-7),<br>  - **ХХВ-ын 28 хэв шинж** |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Оношилгоонд BRCA1 ба BRCA2 ген илрүүлэх мөн CMV илрүүлэг тоолотыг шинээр нэвтрүүлэх ажил хийгдэж байна.<br>- Эмч лаборант нарын хөрвөн ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор суурь сургалтанд хамруулан суралцуулж байна (Хавсралт 5).<br><br>Гүйцэтгэл-70%. |
| 2. | Тусламж, үйлчилгээний чанарын дотоод хяналтын төлөвлөгөө батлан хэрэгжүүлнэ. | 10.0 Эрүүл мэндийн даатгалын сан | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Тусламж, үйлчилгээний чанарын дотоод хяналтын төлөвлөгөөг жил бүр хэрэгжүүлдэг. | Төлөвлөсөн арга хэмжээг 90%-иас доошгүй хэрэгжүүлсэн байна. | Тусламж, үйлчилгээний чанарын дотоод хяналтын төлөвлөгөөг батлуулан, дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:<br>- ЭМТҮЧАБА-ны төлөвлөгөөний дагуу хамтарсан болон багаар 21 тасаг, албад 80 гаруй удаагийн дотоод хяналт, тойрон үзлэг хийж, 60 гаруй зөрчлийг илрүүлсэн. Нийтлэг гарсан зөрчлийг арилгуулахаар арга хэмжээнүүдийг авч ажилласан.<br>- Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор хийгдэж буй дотоодын хяналт үнэлгээний үед холбогдох дүрэм журам стандарт зөрчсөн тохиолдлуудыг бүртгэж "Анхааруулах хуудас"-ыг 7 ажилтанд, "Шаардах хуудас"-ыг 5 ажилтанд хүргүүлж, хугацаат үүрэг даалгавар өгсөн.<br>- Дотоод хяналтыг хийхдээ: Батлагдсан хуваарийн дагуу хийдэг. |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хавсралт 6: Тусламж, үйлчилгээний чанарын дотоод хяналтын төлөвлөгөө төлөвлөгөөний хэрэгжилт<br><br>Гүйцэтгэл-100%. |
| 3. | Дурангийн төв байгуулна. | 1.400 | - Засварын ажлын гүйцэтгэлийн хувь<br>- Дурангийн тусламж үйлчилгээнд хамрагдсан хүний тоо | Засварын зураг болон ТЭЗҮ хийгдсэн. | Засварын ажил бүрэн дууссан байна.<br>Дурангийн тусламж үйлчилгээнд хамрагдсан хүн 30 хүртэл хувиар нэмэгдсэн байна. | Дурангийн төвийн засварын ажлын зураг төсөл ТЭЗҮ хийгдсэн. Тавантолгой ХХК-аас санхүүгийн дэмжлэг авч, засварын ажлын зураг, газар хөдлөлтийн болон эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн.<br><br>Гүйцэтгэл-60%. |
| 4. | Эмнэлзүйн тасгуудын чанарын шалгуур үзүүлэлтүүд, үнэлэх журмыг баталж, эмнэл зүйн чанарын үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу тогтмол хийнэ. | 1.0 Эрүүл мэндийн даатгалын сан | - Батлагдсан үнэлгээний журам<br>- Шалгуур үзүүлэлтүү-дийн хэрэгжилтийн хувь<br>- Үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | Эмнэлзүйн чанарын шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн боловсруулж байна. | Үнэлгээний журмыг батлан мөрдсөн байна.<br>Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг 90%-иас доошгүй хангасан байна.<br>Зөвлөмжийг 90%-иас доошгүй хэрэгжүүлсэн байна. | ХСҮТ-ийн Ерөнхий захирлын 2023.10.03-ны өдрийн А/63 тоот "Эмнэлзүйн чанарын нийтлэг болон тасаг албаны өвөрмөц шалгуур үзүүлэлт, үнэлэх журам"-ыг баталснаар эмнэлзүйн чанарын үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу тогтмол хийж байна.<br><br>Гүйцэтгэл-100%. |
| 5. | Төвөгтэй хүнд тохиолдлын | | - Зохион байгуулсан | Туяа эмчилгээний тасаг 8 удаа олон | Сард нэгээс доошгүй удаа олон | - Эмнэлзүйн хүнд төвөгтэй хорт хавдрын 147 тохиолдолд олон мэргэжилтний зөвлөгөөнийг дотооддоо зохион |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | менежментийг олон улсын Tumor board (олон мэргэшлийн эмч нарын зөвлөгөөн) –өөр шийдвэрлэдэг болно. | | зөвлөгөөний тоо<br>- Шийдвэрлэсэн тохиолдлын хувь | улсын олон мэргэшлийн эмч нарын зөвлөгөөн зохион байгуулсан | улсын эмч нарын зөвлөгөөн зохион байгуулж, шаардлагатай бүх тохиолдлын 90 хүртэл хувьд оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэсэн байна. | байгуулж, эмчилгээ, хяналтын асуудлыг шийдвэрлэсэн.<br>- Шинээр оношилогдсон болон дахисан хавдартай өвчтөний эмчилгээний асуудлыг эмч нарын хамтарсан зөвлөгөөнөөр 100% шийдвэрлэж байна.<br>- "Олон мэргэшлийн эмч нарын олон улсын цахим зөвлөгөөн"-д долоо хоног бүр оролцож байна. Ингэснээр ХСҮТ-ийн эмч нар олон улсын цахим зөвлөгөөнийг 161 удаа хамтран зохион байгуулж, 116 өвтөний оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэсэн. Энэ хүрээнд:<br>- АНУ-ын Юта ИС-ийн эмнэлэг,<br>- ОУАЭА-ийн Ази Номхон далайн эргийн туяа эмчилгээний эмч нарын сүлжээ,<br>- Тайваний их сургуулийн эмнэлэг,<br>- ОХУ-ын Герцены нэрэмжит радиологи, онкологийн судалгааны төв,<br>- Герман улсын эмнэлгүүдтэй виртуал хэлбэрээр хамран ажиллалаа.<br>Гүйцэтгэл-100% |
| 6. | CAP /College of American Pathologists/ протоколыг үндэсний түвшинд нэвтрүүлэх бэлтгэл хангана. | 50.0<br><br>Эрүүл мэндийн даатгалын сан | - Орчуулж, хэвлүүлсэн протокол<br>- Сургасан эмч, мэргэжилтний тоо | CAP шинэчилсэн протоколыг Хавдар судлалын үндэсний төвд 2021 оноос хэрэгжүүлж эхэлсэн. | Протоколыг орчуулж, хэвлүүлсэн байна. Аймаг, дүүргийн 30-аас доошгүй эмч мэргэжилтэнг сургалтад хамруулж, шинэ | - College of American Pathology (CAP)-ийн 99 загвар протоколын мэс заслын эдийн шинжилгээ болон хавдрын эдийн шинжилгээнд 69 протоколийг мөрдөн ажиллаж байна.<br>- CAP протоколийг Эмгэг судлалын үндэсний төвийн эмч нартай хамтран |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аргачлалд сургасан байна. | орчуулан батлуулахаар Эрүүл мэндийн хөгжлийн төвд илгээсэн.<br>- Хематологи ба хематопатологийн оношилгоо, лабораторийн чанарын хяналтын суурь ойлголтууд Олон улсын сургалтад "САР протоколын танилцуулга" сэдвээр хичээл зааж, улсын төв эмнэлгүүд, аймаг дүүргийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 60 эмгэг судлаач эмч оролцсон.<br><br>Гүйцэтгэл-100% |
| 7. | Цусны сийвэн шүүх /Plasmapheresis/ эмчилгээг нэвтрүүлнэ. | 15.0<br><br>Эрүүл мэндийн даатгалын сан | - Батлагдсан эмчилгээний протокол<br>- Эмчилгээ хийлгэсэн хүний тоо<br>- Сургалтанд хамрагдсан эмч, мэргэжилтний тоо | Элэг шилжүүлэн суулгах мэс засалд одоогоор нэвтрээгүй байна. | Эмчилгээний протоколыг батлуулж, 10 болон түүнээс цөөнгүй хүнд эмчилгээ хийсэн байна.<br>10-аас доошгүй эмч, мэргэжилтэнийг сургалтад хамруулсан байна. | **Протокол:** Цусны бүлэг өөр өвчтөний эмчилгээнд цусны сийвэн шүүх /Plasmapheresis/ эмчилгээний протоколыг боловсруулж, Эмнэлзүйн хорооны хурлаар батлуулсан.<br>**Сургалт:** IVCO XXK-аас зохион байгуулсан сургалтад Эрчимт эмчилгээний тасгийн 2 эмч, 2 сувилагч, БНСУ-ын Самсунг Медикал эмнэлэгт Элэг шилжүүлэн суулгах алба болон Эрчимт эмчилгээ, хагалгаа мэдээгүйжүүлгийн тасгийн 6 эмч сургалтад хамрагдсан.<br>**Эмчилгээг нэвтрүүлэх:** CRRT аппарат ашиглан элэг шилжүүлэн суулгасан 2 өвчтөнд цус шүүх эмчилгээ амжилттай хийсэн.<br><br>Гүйцэтгэл-100%. |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| 8. | Яаралтай тусламжийн тасагт газ-анализатор, холтер ЭКГ зэрэг тоног төхөөрөмж суурилуулан тусламж үйлчилгээнд ашиглана. | 50.0<br><br>Эрүүл мэндийн даатгалын сан | Шинээр суурилуулсан тоног төхөөрөмжүүд ашиглан оношилгоо, эмчилгээ хийсэн тоо | Яаралтай тусламжийн тасагт тухайн төхөөрөмжүүд байхгүй. | Яаралтай тусламжийн тасаг газ-анализатор, холтер ЭКГ тус бүр 1-ийг суурилуулж, 100-аас цөөнгүй хүнд тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна. | Яаралтай тусламжийн тасгийг дараах тоног төхөөрөмжөөр хангасан. Үүнд:<br>- Холтер ЭКГ (2023 оны 10 сард): 20 өвчтөний оношилгоонд ашиглаад байна.<br>- Mindray Z-50 маркийн Эхо аппарат: тасгаар үйлчлүүлсэн 1000 хүнд оношилгоо, 220 хүнд эхо хяналтын дор эмчилгээний ажилбар хийгдсэн.<br>Гүйцэтгэл-100%. |
| 9. | "Халдвараас сэргийлэх хяналтын жил" болгон зарлаж, халдвараас сэргийлэх ажлын тусгай төлөвлөгөө батлан хэрэгжүүлнэ. | 3.3<br>Эрүүл мэндийн даатгалын сан | - Төлөвлөгөө-ний хэрэгжилтийн хувь<br>- Тандалтын тайлан | 2022 онд эмнэлгийн халдварын тандалт 2 удаа хийгдэж 41 зөрчил илэрсэн. 12 чиглэлээр 8 удаа 512 эмч ажилтанд халдвараас сэргийлэх сургалт зохион байгуулсан. | Төлөвлөсөн ажлыг 90%-иас доошгүй хэрэгжүүлсэн байна.<br>Тандалтын үр дүнг тогтмол тайлагнаж, хариу арга хэмжээг цаг тухай бүрт авч хэрэгжүүлсэн байна. | ХСҮТ-ийн Ерөнхий захирлын тушаалаар 2023 оныг "Эмнэлгийн тусламж үйлчилгээний халдвараас сэргийлэх хяналтын арга хэмжээг сайжруулах" жил болгон зарласан. Энэ жилийн хүрээнд 7 бүлэг зорилт, 69 заалт бүхий үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлсэн.<br>Хавсралт 7: Эмнэлгийн тусламж үйлчилгээний халдвараас сэргийлэх хяналтын арга хэмжээг сайжруулах" жилийн төлөвлөгөөний хэрэгжилт<br><br>Гүйцэтгэл-100%. |
| 10. | Дурангийн мэс заслын хувийг нэмэгдүүлнэ. | 400.0<br><br>Эрүүл мэндийн даатгалын сан | - Дурангийн мэс заслын эзлэх хувь | Ерөнхий мэс заслын тасаг-0,5%<br>Улаан хоолой-19,3%, уушиг-57,4%,<br>голт -100%, | Хоол боловсруулах замын хавдрын, бүдүүн гэдэсний хавдар, урологийн хавдрын мэс заслын ≤10%, | Хорт хавдрын мэс эмчилгээнд хөнөөл багатай мэс заслын аргыг түлхүү ашиглах замаар хавдрын мэс засал эмчилгээний дараах хүндрэлийг багасгах, хавдартай өвчтөний амьдралын чанарыг сайжруулах зорилт дэвшүүлэн ажиллаж байна. |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эмэгтэйчүүдийн хавдрын мэс заслын хувь-21.5% байна. | Цээжний хөндийн мэс заслын ≤50%, Эмэгтэйчүүдийн мэс заслын ≤30% -ийг дурангийн аргаар хийсэн байна. | Энэ хүрээнд дурангийн мэс заслын тоног төхөөрөмжөөр тасралтгүй ханган ажиллаж байна. 2023 онд нийт мэс заслын 21.4 хувийг дурангийн аргаар хийсэн нь өнгөрсөн оныхоос 5,4 хувиар өссөн байна. Цээжний хөндийн мэс заслын тасагт хийсэн дурангийн мэс засал:<br>- Уушгины хагалгаа (Wedge resection)-ны 97 хувийг,<br>- Уушгины дэлбэн тайрах мэс заслын 85 хувийг,<br>- Улаан хоолой (Ivor-Lewis) мэс заслын 63.5 хувийг,<br>- McKeown мэс засал болон голтын хавдрын мэс заслын 100 хувийг,<br>Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн дурангийн мэс заслын эзлэх хувь-40.6%.<br><br>Гүйцэтгэл-100% |
| 11. | Нөхөн үржихүйн эрхтэн хадгалах мэс заслын тоог нэмэгдүүлнэ. | 110.0 Эрүүл мэндийн даатгалын сан | Эрхтэн хадгалах мэс заслын хувь | 2021, 2022 онд нийт мэс заслын дотор нөхөн үржихүйн эрхтэн хадгалах мэс заслын дундаж-53% | 2023 онд Нөхөн үржихүйн эрхтэн хадгалах мэс засал нийт хагалгааны 55%-иас доошгүй хувьд хийсэн байна. | 2023 оны эхний 11 сарын байдлаар Эмэгтэйчүүдийн мэс заслын тасагт 992 мэс засал хийгдсэн байна. Үүнээс нөхөн үржихүйн эрхтэн хадгалах 621 буюу 62,6 мэс засал хийгдсэн. Нийт мэс заслын дотор нөхөн үржихүйн эрхтэн хадгалах мэс заслын хувь 62.6% байна.<br><br>Гүйцэтгэл-100%. |
| 12. | Хөх хадгалах мэс заслын хувийг нэмэгдүүлнэ. | 100.0 Эрүүл мэндийн | Хөх хадгалах, нөхөн сэргээх мэс заслын эзлэх хувь | 2022 онд хөх хадгалах мэс | Нийт мэс заслын доторх хөх хадгалах мэс заслын эзлэх | 2023 оны эхний 11 сарын байдлаар хөхний хорт хавдрын 241 мэс засал хийснээс хөх |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | даатгалын сан | | засал 47 хувьтай байсан | хувь- ≥50%-д хийсэн байна. | хадгалах 96 буюу 40.24 хувьд хөх хадгалах мэс засал хийгдсэн.<br>Гүйцэтгэл-90% |
| 13. | Монголд эмчлэхгүй байгаа элэг, уушигны хавдрын стереотактик биеийн туяа эмчилгээ (SBRT) нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангана. | 1,2 сая Евро<br><br>Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА) MON6021 төсөл | - Батлагдсан элэг, уушигны хавдрын стереотактик биеийн туяа эмчилгээний протокол<br>- Батлагдсан чанарын хяналтын протокол<br>- Сургалтанд хамрагдсан мэргэжилтэний тоо | ОУАЭА-ийн MON 6021 төслийн хүрээнд 1 эмч Япон улсын Хирошима хотын их сургуулийн эмнэлэгт 6 сарын хугацаатай суралцаж байна. | Элэг, уушигны хавдрын стереотактик биеийн туяа эмчилгээний болон Чанарын хяналтын протоколыг тус тус боловсруулж, батлуулсан байна. 3 эмч, 1 физикч, 2 техникч нийт 6 эмч, мэргэжилтэнийг сургалтанд хамруулсан байна | **Тоног төхөөрөмж:** Шинээр суурилагдсан туяа эмчилгээний Truebeam аппарат болон суурилагдсан байсан iX шугаман хурдасгуурт аппаратуудад Амьсгалын хөдөлгөөн зохицуулах нэмэлт хэрэгсэл болон Cone Beam CT – тэй болсноор IGRT ашиглах боломж бүрдсэн.<br>**Сургалт:** Япон улсын Хирошима хотын Их сургуулийн эмнэлэгт 2022 оны 09 сараас эхлэн сургалтууд хуваарийн дагуу хийгдэж, 2 эмч, 2 техникч суралцаж төгссөн ба одоо 1 физикч инженер суралцаж байна.<br>**Удирдамж:** Элэг болон уушгины хавдрын эмнэлзүйн удирдамж боловсруулагдсан, эмнэлзүйн хороогоор батлуулах ажил хийгдэж байна.<br>Гүйцэтгэл-90% |
| 14. | Монгол улсад хийхгүй байгаа эд завсрын дотуур туяа (interstitial brachytherapy) эмчилгээг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангана. | 0.5 сая евро ОУАЭА-MON6022 төсөл | - Суурилуулсан дотуур туяа эмчилгээний аппарат<br>- Батлагдсан эмчилгээний протокол | 2018 онд 3 хэмжээст хөндийн доторх дотуур туяа эмчилгээг нэвтрүүлж одоогоор 60% буюу 360 гаруй хүнд хийгээд байна. | Дотуур туяа эмчилгээний тоног төхөөрөмж, Аппликатор тус бүр нэгийг суурилуулсан байна. Эд завсрын дотуур туяа (interstitial brachytherapy) | ОУАЭА-ийн зөвлөх ирж, 3 хэмжээст дотуур туяа эмчилгээтэй танилцан үнэлгээ хийж, "Эд завсрын дотуур туяа эмчилгээг нэвтрүүлэх боломжтой" гэж дүгнэсэн.<br>2 эмч, 1 эмнэлгийн физикч бэлтгэх саналыг ОУАЭА-д хүргүүлсэн, 2024 оны I улирлаас Энэтхэг улсад тус бүр 2 сар сургах бэлтгэл хийгдэж байна.-Шаардлагатай тоног төхөөрөмжийн захиалга хийгдсэн ба |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эмчилгээний протокол боловсруулж батлуулсан байна. | одоогоор худалдан авалтын шатанд явагдаж байна.<br><br>Гүйцэтгэл- 80% |
| 15. | Төлөвлөлтийн компьютер томографи аппарат суурилуулан туяа эмчилгээний төлөвлөлтөнд ашиглана. | 460,000 евро ОУАЭА MON6020 төсөл | - Суурилуулсан төлөвлөлтийн компьютер томографийн аппарат ашиглан эмчилгээнд орсон хүний тоо | Siemens Singo.Sim компьютер томографи аппарат худалдан авсан бөгөөд өрөөний засварын ажил хийгдэж байна. | Төлөвлөлтийн компьютер томографийн аппарат суурилуулж, 400-аас цөөнгүй хүнд туяа эмчилгээний төлөвлөлтийг хийсэн байна. | Төлөвлөлтийн КТГ аппарат суурилагдаж, сургалтууд хийгдэж дууссан ба 2023.03. 27-ны өдрөөс оношилгоо, эмчилгээнд ашиглаж эхэлсэн. 2023 онд 670 хүнд туяа эмчилгээний төлөвлөлтийг тухайн КТГ-ын аппаратаар хийсэн байна.<br><br>Гүйцэтгэл- 100% |
| 16. | Монгол улсад хийгдэхгүй байгаа улаан хоолойн хорт хавдрын эрчмийг тохируулсан туяа эмчилгээ (IMRT) -ний бэлтгэл хангана. | - | - Батлагдсан улаан хоолойн хорт хавдрын IMRT эмчилгээний протокол | 2021 онд боловсруулсан 3 хэмжээст конформал туяа эмчилгээний удирдамжийг мөрдөн ажиллаж байна | Улаан хоолойн хорт хавдрын IMRT эмчилгээний протокол боловсруулж батлуулсан байна. | Эрчмийг тохируулах туяа эмчилгээ болон ээлхүүнт нуман туяа эмчилгээний эмнэлзүйн зааврыг боловсруулж, Эмнэлзүйн хороогоор батлуулсан.<br><br>Гүйцэтгэл- 100% |
| 17. | Хими эмчилгээнд хиймэл судас байрлуулах Chemoportae ажилбарыг нэмэгдүүлнэ. | 60.0 Эрүүл мэндийн даатгалын сан | Ажилбарын тоо | 60 хүнд хиймэл судас байрлуулах Chemoportae ажилбар хийгдсэн. | Chemoportae ажилбарын тоо өмнөх оныхоос нэмэгдсэн байна. | 2023 оны оны эхний 11 сарын байдлаар 26 хүнд хиймэл судас байрлуулах Chemoportae ажилбарыг амжилттай хийсэн.<br><br>Гүйцэтгэл- 70% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| 18. | Хөнгөвчлөх эмчилгээний тасгийн үйлчлүүлэгчдийн ар гэр, асран хамгаалагч нарт гэрийн асаргааны чиглэлээр сургалт зохион байгуулна. | 15.0<br><br>Эрүүл мэндийн даатгалын сан | - Сургалтад хамрагдсан хүний хувь<br>- Боловсруулсан гарын авлага | Сургалтын хөтөлбөр, гарын авлага байхгүй | Асран хамгаалагчдын 60 ба түүнээс дээш хувийг сургалтад хамруулсан байна. Асран хамгаалагчид зориулсан "Гэрийн асаргаа"-ны гарын авлага боловсруулсан байна. | – Хөнгөвчлөх эмчилгээний тасгаар үйлчлүүлсэн 400 гаруй өвчтөний асран хамгаалагчийн 70%-д нь гэрийн асаргааны сургалт зохион байгуулсан.<br>– ХААН банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр "Хүнд өвчтөний гэрийн асаргаа, сувилгаа" гарын авлагыг шинэчлэн боловсруулж, 500 ширхэгийг хэвлэн, ар гэр, асран хамгаалагчид түгээсэн.<br><br>Гүйцэтгэл-100% |
| 19. | Улаанбаатар хотын 6 дүүрэг, 4 аймгийн өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нарт "Хөнгөвчлөх эмчилгээ" сэдэвт ажлын байрны сургалт зохион байгуулна. | 5.0<br>Эрүүл мэндийн даатгалын сан | - Боловсруулсан сургалтын хөтөлбөр<br>- Хамрагдсан эмч, мэргэжилтэний тоо | 2019 онд Улаанбаатар хотын 6 дүүргийн эмч нарт сургалт хийсэн. КОВИД цар тахлаас хойш сургалт хийгдээгүй байна. | "Хөнгөвчлөх эмчилгээ" сэдэвт багц цагийн сургалтын хөтөлбөр батлуулж, Улаанбаатар хотын 6 дүүрэг, 4 аймгийн өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нарт зориулсан сургалт зохион байгуулж, 200-аас цөөнгүй эмч, сувилагчийг сургалтад хамруулсан байна. | – "Хөнгөвчлөх эмчилгээ, өвдөлтийн менежмент" сэдэвт 1 багц цагийн сургалт зохион байгуулж, Дархан уул, Орхон, Өмнөговь, Увс, Дорнод аймгийн өрх, сумын нийт 390 эмч, мэргэжилтэн хамрагдлаа.<br>– "Хөнгөвчлөх сувилахуйн тусламж үйлчилгээг сайжруулах нь" 3 сарын аяны хүрээнд ХУД-ийн 7-р хороо, БЗД-ийн 26-р хороо, СХД-ийн 23-р хорооны өрхийн эрүүл мэндийн төвүүдэд "Хөнгөвчлөн сувилахуй" ажлын байрны дагалдан сургалтыг зохион байгуулж, нийт 146 эмнэлгийн мэргэжилтэнүүд хамрагдлаа.<br><br>Гүйцэтгэл-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| 20. | Хавдрын даван туулагчийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 4.0 Эрүүл мэндийн даатгалын сан | - Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь<br>- Хөтөлбөрт хамрагдсан хүний тоо | 2022 оноос даван туулагчдын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. | - Хөтөлбөрийн хэрэгжилт 80%-иас доошгүй байна.<br>- Хөтөлбөрт 100-аас цөөнгүй даван туулагчийг хамруулсан байна. | 2022 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хүрээнд хавдрын даван туулагчдыг сайн дурын үйл ажиллагаанд уриалах, холбоо тогтоох, олон нийтийн үйл ажиллагаанд оролцуулах зорилгоор дараах ажлыг хийлээ. Үүнд:<br>- Умайн хүзүү, хөхний хавдрын 2 даван туулагчийн сайн дурын үйл ажиллагааны талаар тусгай нэвтрүүлгийг МҮОНТ-тэй хамтран зохион байгуулсан.<br>- Наран ижий заяа НҮТББ-аас зохион байгуулдаг хавдрын даван туулагчдын нөлөөллийн 4 удаагийн цуврал уулзалтад хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлсэн.<br><br>Гүйцэтгэл 90%. |
| 21. | "Хавдрын үеийн сувилгааны гардан ажилбарын гарын авлага" -ыг шинэчлэн боловсруулж, хэвлүүлнэ. | 10.0<br><br>Эрүүл мэндийн даатгалын сан | Сургалтад хамрагдсан шинэ сувилагчийн хувь | 2013 онд "Сувилгааны гардан ажилбарын гарын авлага" номыг боловсруулан хэвлэж, сувилахуйн сургалтад ашиглаж байна. | Шинээр ажилд орсон сувилагчийг 100% сургалтад хамруулж, гарын авлагаар хангасан байна. | Хавдрын үеийн сувилгааны гардан ажилбарын гарын авлага" 2013 он номыг дахин хэвлүүлэхээр сайжруулалтыг хийж боловсруулсан. Энэхүү сувилахуйн гардан ажилбарын гарын авлага ном нь MNS4621:2008 стандартын гардан үйлдлийг багтаасан зурагт ном бөгөөд Жайкагийн сайн дурын мэргэжилтэн сувилагч нартай хамтран боловсруулсан ном гарын авлага юм. Гардан үйлдэлийн стандартын ном нь шинэ сувилагч нарт болон бусад сувилагчдад өдөр тутмын гарын авлага болдог. Ном хэвлэх зардлын |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тооцоог хийж батлуулсан ба 12-р сард 200ш хэвлүүлэхээр хэвлэлийн үйлдвэрт гэрээг хийсэн байна.<br><br>Гүйцэтгэл-80% |
| **ЗОРИЛТ 4: ХОРТ ХАВДРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, СУРГАЛТ ЭРХЛЭХ** | | | | | | |
| 1. | Эрдэм судлалыг хөгжүүлэх зорилгоор батлагдсан "Сургалтын дэмжлэг үзүүлэх журам"-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 15.0<br><br>Эрүүл мэндийн даатгалын сан | - Тэтгэлэгт хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо<br>- Магистр хамгаалсан эмч, мэргэжилтний тоо | -14 эмнэлгийн мэргэжилтэн магистрийн зэрэг хамгаалсан ба 10 хүнд 10,2 сая төгрөгийн тэтгэлэг олгосон. | Магистр, докторын зэрэг хамгаалсан эмч, мэргэжилтэн 8-аас цөөнгүй хүнд 10 сая төгрөгөөс дээш тэтгэлэг олгосон байна.<br>10 хүртэл эмч мэргэжилтэн магистрийн зэрэг хамгаалсан байна. | Хавдрын эрдэм судлалыг хөгжүүлэх зорилгоор ХСҮТ-ийн Ерөнхий захирлын 2022 оны А/31 тоот тушаалаар батлагдсан "Сургалтын дэмжлэг үзүүлэх" журмын дагуу 2022-2023 онд Магистрийн зэрэг хамгаалсан тус төвийн 26 эмч, сувилагч, мэргэжилтэн нийт 26 сая төгрөгийн тэтгэлгийг олгоод байна. Уг журам хэрэгжсэнээр эрдмийн зэрэг горилох эмч мэргэжилтний тоо жилээс жилд нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал:<br>- 2022 онд 10'229'360 төгрөгийг 10 ажилтан (7 эмч, 1 эм зүйч, 2 сувилагч)-д,<br>- 2023 онд 15'741'600 төгрөгийг 16 ажилтан (4 эмч, 10 сувилагч, 2 мэргэжилтэн)-д тус тус олгоод байна.<br>Гүйцэтгэл-100% |
| 2. | "Хавдар судлалын тулгамдсан асуудал-2023" эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна. | 60.0<br><br>Эрүүл мэндийн даатгалын сан | - Хэвлүүлсэн сэтгүүлийн тоо<br>- Нийтлүүлсэн бүтээлийн тоо<br>- Хэлэлцүүлсэн илтгэлийн тоо | "Хавдар судлалын тулгамдсан асуудлууд" үндсэн (1) салбар (5) хуралдаанаар зохион байгуулж, | Хавдар судлалын тулгамдсан асуудал хурлын 40 хүртэл бүтээлийг Хавдар судлал сэтгүүлд нийтэлсэн байна. | "Хавдар судлалын тулгамдсан асуудал" сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг Сетунари ХХК, Новартис ХХК, Монос трейд ХХК, Монголын хавдар судлаач эмч нарын нийгэмлэгтэй хамтран "NOVOTEL" зочид буудал болон ХСҮТ-ийн хурлын танхимд дараах хуралдаанаар зохион байгууллаа. Үүнд: |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 400 гаруй эмч мэргэжилтнүүд хамрагдсан байна. | Хуралд 300-аас олон эмч мэргэжилтэнг оролцуулж, 20-25 судалгааны ажлын үр дүн, шинэ технологийг хэлэлцүүлсэн байна. | **Үндсэн хуралдаан** (2023.09.15): "Хорт хавдрын салбарын хөгжлийн чиг хандлага", "Монгол улсын хавдар судлалын салбарын судалгаа, шинжилгээний ажлын үр дүн" гэсэн 2 хэсэгтэйгээр зохион байгуулагдсан.<br>**Салбар хуралдаан:** (2023 оны 09-10 сард) дараах 5 салбар хуралдаанаар зохион байгууллаа. Үүнд:<br>1. "Хавдрын хими, бай эмчилгээ" сургалт,<br>2. "Хавдрын ангиографийн эмчилгээ" сургалт,<br>3. "Монгол улс дахь хүний папиллома вирусийн шалтгаант умайн хүзүүний хорт хавдрын оношилгоо, эмчилгээний менежмент" сургалт<br>4. "Эмнэлзүйн ховор тохиолдол" хэлэлцүүлэг,<br>5. "Хавдрын сувилахуйн тусламжийн өнөөгийн хэрэгцээ, цаашдын чиг хандлага" эрдэм шинжилгээний бага хурлыг тус тус зохион байгууллаа.<br>**Шилдэг илтгэл:** Тус хурлаар зочин илтгэгчийн 5, судалгаа, шинжилгээний 30 илтгэлийг хэлэлцүүлж, 8 шилдэг илтгэлийг шалгаруулан, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.<br>ХСҮТ-ээс жил тутам эрхлэн гаргадаг **"Хавдар судлал" сэтгүүлд** эрдэм шинжилгээний 52 бүтээлийн эмхэтгэл хэвлэгдэж, 300 ширхгийг түгээлээ. Хуралдааны үеэр МҮОНРТ, UBS, C1, TV9, TV5, ТВ8, ETV, Eagle, Монгол HD, TV 25, МҮРадио, Монголын радио болон Өдрийн |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээ, Зууны мэдээ зэрэг 14 хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний талаарх ярилцлага, мэдээллийг хүн амд хүргэлээ.<br><br>Гүйцэтгэл-100%. |
| 3. | Элэг цөс, нойр булчирхайн мэс заслын тасгийн 15 жилийн ойд зориулсан "International Congress of HCC" эрдэм шинжилгээний олон улсын хурал зохион байгуулна. | 60.0 Эрүүл мэндийн даатгалын сан | - Оролцсон улс/ байгууллагын тоо<br>- Шинээр танилцуулсан технологийн тоо | - | Япон, Солонгос, ОХУ, Тайвань зэрэг орны хавдар судлалын төв болон эмнэлгийн 20-иос цөөнгүй эрдэмтэн судлаачид оролцож, илтгэл хэлэлцүүлсэн байна. 2 ба түүнээс дээш мэс засал эмчилгээний шинэ арга, технологи танилцуулсан байна. | ХСҮТ-ийн Элэг цөс, нойр булчирхайн мэс заслын тасгийн 15 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд МЭЦНБН-тэй хамтран 2023.08.08-10-ны өдрүүдэд сургалт ба хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Үүнд:<br>**Сургалт:** "Монголын элэг цөс, нойр булчирхайн мэс заслын эмч нарын 7 хоног" сэдэвт 1.5 багц цагийн чадавхижуулах сургалтыг ХСҮТ-ийн хурлын зааланд зохион байгуулж, нийт 390 эмнэлгийн мэргэжилтэн оролцсон.<br>Мөн "Элэгний хавдрын асуудлыг шийдэх арга зам" хэлэлцүүлгийг Засгийн газрын ордонд зохион байгуулж, 130 гаруй шийдвэр гаргагч нар оролцлоо.<br><br>Гүйцэтгэл-100% |
| 4. | Монголын дурангийн мэс засалчдын (MACLES-7th annual conference) 7-дахь удаагийн хурлыг зохион байгуулна. | 5.0<br><br>Эрүүл мэндийн даатгалын сан | - Хэлэлцүүлсэн илтгэлийн тоо<br>- Оролцогчдын тоо | 6 удаа зохион байгуулагдсан. | Монголын дурангийн мэс засалчдын 7-дахь удаагийн хуралд 150 эмч, резидент эмч нар оролцож, 10-15 илтгэл | Монголын дурангийн мэс засалчдын (MACLES-7th annual conference) 7-дахь удаагийн хурлыг 2023.08.08-10-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 520 хүн оролцлоо.<br><br>Гүйцэтгэл-100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэлэлцүүлсэн байна. | |
| 5. | Төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтыг хуваарь, хөтөлбөрийн дагуу зохион байгуулна. | 62.0<br><br>Сургалтын төлбөр<br><br>Сургалтын төрийн сан | Суралцаж төгссөн эмч, мэргэжилтэний тоо | Хавдар судлал үндсэн мэргэшил, төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийн дагуу 2022 онд 109 эмч, мэргэжилтэн төгссөн. | Хавдар судлал үндсэн мэргэшлийн резидентур 17 эмч, төрөлжсөн мэргэшил эмч-35, сувилагч- 34, мэргэжил дээшлүүлэх сургалтад эмч-48 тус тус сургаж төгсгөсөн байна. | **Хавдар судлал үндсэн мэргэшлийн сургалтаар:**<br>- 2022-2023 оны хичээлийн жилд суралцаж төгссөн -7 эмч,<br>- 2023-2024 оны хичээлийн жилд шинээр элссэн-13 эмч,<br>- 2023 оны байдлаар 1-2 дамжаанд суралцаж байгаа - 22 резидент эмч,<br>**Хавдрын төрөлжсөн мэргэшлийн** сургалтанд 63 эмнэлгийн мэргэжилтэн суралцаж төгссөн. Үүнд:<br>- Хавдрын хими эмчилгээ судлал - 10 эмч,<br>- Туяа эмчилгээ судлал - 4 эмч<br>- Эмэгтэйчүүдийн хавдар судлал - 7 эмч,<br>- Толгой хүзүүний мэс засал судлал -13 эмч<br>- Хавдрын сувилахуй судлал - 22 сувилагч,<br>- Хөнгөвчлөх эмчилгээний сувилахуй судлал -7 сувилагч,<br>**Мэргэжил дээшлүүлэх сургалтаар** нийт 45 эмч суралцаж төгссөн. Үүнд:<br>- Хавдрын мэс заслын 7 чиглэлээр 42 эмч,<br>- Хавдрын хөнгөвчлөх эмчилгээ - 3 эмч<br><br>Гүйцэтгэл-100%. |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| 6. | Сувилахуйн эмнэлзүйн сургалтын өрөөний дууриймал орчинг шинэчилнэ. | 80.0<br><br>Эрүүл мэндийн даатгалын сан | - Сургалтын өрөөнд хийсэн тохижилт, нийлүүлсэн сургалтын тоног төхөөрөмжийн тоо<br>- Сувилахуйн сургалтад хамрагдсан хүний тоо | Сургалтын бүрэн дууриймал орчин бүрдээгүй байна. | - Сувилахуйн сургалтын өрөөнд засвар хийж, сургалтын 3 төрлийн муляжаар хангасан байна.<br>- Хавдрын сувилахуйн чиглэлээр 100-аас цөөнгүй сувилагчийг дадлага хийлгэсэн байна. | Сувилахуйн сургалтын орчныг бүрдүүлэх зорилгоор дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>- Сувилахуйн сургалтын 30 суудал бүхий өрөөний барилгын засварыг 10-р сард хийж дуусгасан. Сувилахуйн сургалтын өрөөнд шинэ ширээ 15ш, сандал 30ш авахаар төсөвд суулгасан ба 12-р сард авахаар төлөвлөсөн байна.<br>- Хавдар, Хөнгөвчлөхийн сувилахуйн мэргэшүүлэх сургалт, бүх тасгийн сувилагчдын сургалт зэрэгт өрөөг бүрэн ашиглаж байна. Сургалтын орчин сайжирсанд сувилагчдын сэтгэл ханамж дээшилсэн. Мөн сувилахуйн гардан ажилбарын сургалтанд зориулсан 3 төрлийн муляж авахаар 2024 оны төсөвт санал оруулсан.<br><br>Гүйцэтгэл-80% |
| 7. | "Хамтын ажиллагааны гэрээ"-тэй эрүүл мэндийн байгууллагуудад "Ажиллан суралцах" журмыг хэрэгжүүлнэ. | 200.0<br><br>Аймгийн нэгдсэн эмнэлэг<br><br>БОЭТ | - Хамтран ажилласан эмнэлгийн тоо<br>- Аймагт шинээр нэвтрүүлсэн хавдрын тусламж үйлчилгээний төрөл | УНТЭ, УХТЭ, УГТЭ, Сэлэнгэ, Хэнтий, Өмнөговь, Архангай аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч мэргэжилтнүүдийг ажиллан сурах хөтөлбөрийн дагуу сургахаар | Хамтын ажиллагааны гэрээтэй 10 хүртэл эрүүл мэндийн байгууллагад "Ажиллан суралцах журам-"ын дагуу ажиллаж, хавдрын хими, хөнгөвчлөх, мэс засал эмчилгээг | Эрүүл мэндийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд "Ажиллан суралцах" хөтөлбөрийг хэрэгжүүлж, тус төвийн эмч мэргэжилтнүүдийг дараах чиглэлээр мэргэшүүллээ. Үүнд:<br>**Төрөлжсөн мэргэшлийн сургалт (7):**<br>- Хавдрын туяа эмчилгээ судлал-3 эмч,<br>- Мэдрэлийн мэс засал судлал-1 эмч,<br>- Хавдрын хими эмчилгээ судлал-2 эмч,<br>- Эрүүл мэндийн чанар эрсдэлийн удирдлага-1 эмч,<br>**Мэргэжил дээшлүүлэх сургалт (7):** |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | - Аймагт амжилттай хийсэн мэс заслын тоо<br>- Хими болон бай эмчилгээ хийсэн хүний тоо<br>- Сургалтанд хамрагдсан эмч мэргэжилтэний тоо | хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. | 4 хүртэл эмнэлэгт нэвтрүүлсэн байна. Аймгийн нэгдсэн эмнэлэгт 10-аас цөөнгүй мэс засал хийж, хавдрын хими хөнгөвчлөх эмчилгээнд 50 ба түүнээс дээш хүнийг хамруулсан байна. | - Уушиг голтын хавдрын мэс засал-1 эмч,<br>- Элэг цөсний хавдрын мэс засал-2 эмч<br>- Хавдрын сувилахуй судлал-1 сувилагч,<br>- Хөнгөвчлөх эмчилгээний сувилахуй судлал-3 сувилагч<br>**“Хавдрын хими эмчилгээний найруулга зүй”** 2,5 багц цагийн сургалтын хөтөлбөрийг батлуулан, сургалтын эрх авч, ЭМХТ-тэй хамтран зохион байгууллаа. Сургалтанд УГТЭ, УХТЭ, УНТЭ, Говь-Алтай, Дорнод, Архангай, Өмнөговь, Увс, Сэлэнгэ, Дархан-Уул, Дундговь, Орхон аймаг болон Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Багануур дүүргийн нийт 24 эмч, эм найруулагч нар хамрагдсан.<br><br>Гүйцэтгэл-100% |
| 8. | “Ангиографийн оношилгоо, эмчилгээ судлал” төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөр боловсруулан, сургалтын эрх авна. | 1.0 | - Батлагдсан сургалтын хөтөлбөр<br>- ЭМЯ-ны ЭМХЗ-ийн шийдвэр | -Сургалтын хөтөлбөрийн төслийг ЭМХТ-д хүргүүлсэн. | “Ангиографийн оношилгоо, эмчилгээ судлал” төрөлжсөн мэргэшлийн сургалтын эрх авсан байна. | Ангиографийн төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, ЭМЯ-ны Дүрс оношилгооны салбар зөвлөлд болон ЭМХТ-д хүргүүлсэн. ЭМЯ-ны эмнэлгийн мэргэжилтэний хөгжлийн зөвлөлийн 12-р сарын хурлаар хэлэлцэгдэнэ.<br><br>Гүйцэтгэл-80% |
| 9. | Хавдар судлалын үндэсний төвийн 2023-2026 оны | - | - Батлагдсан стратеги төлөвлөгөө | Төслийг боловсруулж | Стратеги төлөвлөгөөг шинэчлэн | ХСҮТ-ийн стратеги төлөвлөгөөг боловсруулж, ЭМ-ийн сайдаар батлуулахаар ЭМЯ-д хүргүүлсэн. |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | стратеги төлөвлөгөөг шинэчлэн батлуулна. | | - Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | ЭМЯ-аар хянуулж санал авсан. | боловсруулж батлуулсан байна. 2023 онд төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилт 90%-иас дээш байна. | Гүйцэтгэл-100% |
| ЗОРИЛТ 5: САНХҮҮГИЙН БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ ХАНГАЖ, ГҮЙЦЭТГЭЛД СУУРИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХ | | | | | | |
| 1. | Төвийн сул ажлын байрыг ил тод нээлттэй сонгон шалгаруулж, хүний нөөцийг бүрдүүлнэ. | - | Сул ажлын байрыг нээлттэй сонгон шалгаруулсан хувь | 2023 онд 100% нээлттэй сонгон шалгаруулсан. | Сул ажлын байрыг 100 хувь нээлттэй сонгон шалгаруулсан байна. | 2023 онд Хавдар судлалын үндэсний төвд шинээр эмч, эмнэлгийн ажилтан авах тухай зарыг дараах мэдээлэл түгээх сувгуудаар зарласан.<br>- Төвийн www.cancer-center.gov.mn цахим хуудас,<br>- Монголын ажлын байрны төв сүлжээ www.zangia.mn сайт,<br>- ЭМХТ-ийн хүний нөөцийн цахим программд,<br>- Төвийн олон нийтийн мэдээллийн самбар,<br>- Төвийн олон нийтэд зориулсан facebook group зэргээр 78 удаа ажлын зарын мэдээллийг гаргасан.<br>Дээрх мэдээллийн хэрэгслээр дараах ажлын байрыг зарласан. Үүнд: |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Зарлалын дагуу хүсэлт гаргасан 132 иргэний материалыг хүлээн авч 40 ажлын байранд дээр сонгон шалгаруулалтын журмын дагуу 44 удаагийн шалгаруулалт явуулан төвийн захиралд танилцуулж сонгон шалгаруулалтад тэнцсэн 66 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулж байна.<br><br>Гүйцэтгэл-100% |
| 2. | Төвийн ажилтнуудын нийгмийн баталгааг дэмжих арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. | 15.0 Эрүүл мэндийн даатгалын сан | - Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь<br>- Ажилагсадын сэтгэл ханамжийн хувь | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 90 хувьтай хэрэгжүүлсэн | Төлөвлөсн арга хэмжээг ≤90% хэрэгжүүлсэн байна.<br>Сэтгэл ханамжийн хувь ≤90% болсон байна. | Ажилтнуудын нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөр батлан бүрэн хэрэгжүүлжсэн байна.<br>Хавсралт 8: Ажилтнуудын нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан<br><br>Гүйцэтгэл- 100% |
| 3. | Эмч, ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх чадамжийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулна. | 3.0<br><br>Эрүүл мэндийн даатгалын сан | - Батлагдсан чадамжийн үнэлгээний шалгуур үзүүлэлт<br>- Батлагдсан шалгуурын дагуу цалин урамшуулал олгосон шийдвэр | Боловсруулж байна. | - Мэс заслын ба мэс заслын бус эмч, сувилагчийн чадамжийн шалгуур тус тус батлагдсан байна.<br>- Шалгуурын дагуу цалин урамшуулалыг | ХСҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/32 тоот тушаалаар "Эмч, ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам"-ыг шинээр боловсруулж, баталсан. Уг журамд дараах үнэлгээг тусгасан. Үүнд:<br>- **Чадамжийн үнэлгээний шалгуур** үзүүлэлтийг тасаг, албаны өвөрмөц үйл ажиллагаанд тулгуурлан, ерөнхий ба гардан үйлдлийн гэсэн 2 шалгуураар тогтоосон, |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүрэн олгосон байна | - **Өөрийн үнэлгээний хуудсыг** шинээр боловсруулж баталсан.<br>Чадамжийн үнэлгээний дагуу нийт 121 эмч, 11 эм зүйч, 4 физикч, 130 сувилагчийн чадамжийг үнэлж, цалингийн тогтолцоог шинэчилсэн.<br><br>Гүйцэтгэл- 100% |
| 4. | ХСҮТ-ийн ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 30.0 Эрүүл мэндийн даатгалын сан | - Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br>- Өвчний улмаас чөлөө авсан ажилтны хувь | 2022 онд эрүүл мэндийг дэмжих чиглэлээр 7-н ажил зохион байгуулсан | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-≤90% байна.<br>Өвчний улмаас чөлөө авсан ажилтны тоо өмнөх оноос буурсан байна. | Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүллээ. Үүнд:<br>**Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт** нийт 440 ажилтан буюу 92 хувь хамрагдсан. Мөн шинээр ажилд орсон 20 ажилтан, урт хугацааны чөлөөнөөс ажилдаа орсон 8 ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан хөдөлмөрийн гэрээ байгуулсан.<br>УСҮ-ийг дараах байдлаар зохион байгуулсан. Үүнд:<br>- Эмчийн үзлэг (6): Толгой хүзүү, Хөх, Ерөнхий мэс засал, Зүрх судас, Дотор, Эмэгтэйчүүд<br>- Багажийн шинжилгээ (3): ЭХО, дуран, рентген<br>- Лабораторийн шинжилгээ (4 багц)<br>**Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн судалгаа** хийж, үр дүнг тооцсон. Энэ хүрээнд:<br>- Ажлын байрны дасгал хөдөлгөөнийг дэмжих 1 сарын хөтөлбөр, |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - 6 төрөлт спортын наадам<br>- "Энэ жилдээ эрүүл жиндээ аян"-д нэгдэж, явган алхалтын клуб байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.<br>**Үр дүн:** Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр өвчний улмаас чөлөө авсан ажилтны хувь өмнөх оны мөн үеэс 10,4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.<br>Хавсралт 9. ХСҮТ-ийн ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн тайлан.<br>Гүйцэтгэл-100% |
| 5. | Амь тэнссэн үеийн амилуулах суурь тусламжийн сургалтыг зохион байгуулна. | 0.5 Эрүүл мэндийн даатгалын сан | Сургалтад хамрагдсан ажиллагсадын хувь | 2022 онд Амь тэнссэн үеийн амилуулах суурь тусламжийн сургалтыг 2 удаа зохион байгуулсан. | Сургалтад бүх ажиллагсадыг бүрэн хамруулсан байна. | Тус төвийн Яаралтай тусламжийн тасгаас "Амь тэнссэн үеийн амилуулах суурь тусламжийн сургалт"-ыг 5 дахь жилдээ зохион байгуулж, тасаг, албадын 140 гаруй эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа.<br>Сургалтаар амилуулах суурь тусламжийн үндсэн ойлголтын талаарх онолын мэдлэг эзэмшиж, сургалтын муляж бүхий хэрэгсэл дээр дадлага сургалтыг зохион байгуулсан нь үр өгөөжтэй байсан.<br><br>Гүйцэтгэл-100% |
| 6. | Эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаад улсад урт, богино хугацааны цахим болон танхимын сургалтад хамруулна. | 100.0 Эрүүл мэндийн даатгалын сан | - Гадаад сургалтын тоо<br>- Хамрагдсан хүний тоо<br>- Нэвтрүүлсэн шинэ технологи | 2022 онд 45 эмч, мэргэжилтэн гадаадын өндөр хөгжилтэй орнуудад урт болон богино хугацааны | Нейро-онкологи, стереотактик туяа эмчилгээ, цагаан мөгөөрсөн хоолойн хавдрын мэс засал, яс, зөөлөн эдийн нөхөн сэргээх мэс | **Богино хугацааны гадаад сургалт:**<br>Нийт 80 эмнэлгийн мэргэжилтнийг богино хугацааны гадаад сургалтад хамруулсны 78,7% (63)-ийг багийн сургалт эзэлж байна. Үүнд:<br>- Хөхний хавдрын мэс заслын баг (4): БНСУ<br>- Урологийн мэс заслын баг –(2): БНСУ |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | сургалтад хамрагдсан. | засал, онкоурологи болон хөхний хавдрын нөхөн сэргээх мэс заслын чиглэлээр нийт 20 эмч эмнэлгийн мэргэжилтэнг гадаад улсад урт, богино хугацааны цахим болон танхимын сургалтад хамруулсан байна. | - Элэг шилжүүлэн суулгах мэс заслын баг (6): БНСУ<br>- Толгой хүзүүний нөхөн сэргээх мэс засал (Нейро-Онкологийн баг) -7.<br>- Эмгэг судлалын баг (4): ОХУ, Швейцар<br>- Ангиографийн баг (3)-Хятад улс,<br>- Ерөнхий мэс заслын баг (6)-Вьетнам, БНСУ улс<br>- Туяа эмчилгээний баг (10): Япон, Австри, Румин, Индонез улс<br>- Элэгний хавдрын мэс заслын баг (3): БНСУ,<br>- Цээжний хөндийн мэс заслын баг (3): БНСУ, Швейцар улс<br>- Эмэгтэйчүүдийн мэс заслын баг (6): Франц, БНСУ<br>- Клиник эм зүйн баг (4): Энэтхэг улс<br>- Хими эмчилгээний баг (3): Индонез, Австри улс<br>- НЭМ, сургалтын баг (2): БНСУ<br>**Урт хугацааны (2-3 жил) гадаад сургалтанд** хамрагдсан тус төвийн дараах 9 ажилтаны нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцаж байна. Үүнд:<br>- Япон, Хятад улсад докторантурын сургалтад хамрагдсан 5 эмч,<br>- Англи, БНСУ-д магистрантурын сургалтад хамрагдсан 1 эмч, 3 сувилагч,<br>2023 оны байдлаар гадаад сургалтанд хамрагдсан 1 эмч Япон улсад Анагаах |

| Д/д | Стратеги төлөвлөгөө | Санхүү-жилт /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ухааны доктор, 2 сувилагч БНСУ-д Сувилахуйн магистрийн зэрэг амжилттай хамгаалж ирсэн.<br><br>Гүйцэтгэл-100% |
| 7. | Байгууллагын өргөтгөлийн хяналтын камерын системийг шинэчилж, шинэ IP хяналтын камерын системтэй болно. | 60.0 Эрүүл мэндийн даатгалын сан | Шинээр суурилуулсан өргөтгөлийн хяналтын камерын тоо | Одоогийн камер нь аналоги системтэй байна. | Нийт 63 ширхэг камер байршуулсан байна. | Тус төвийн дараах байршилд нийт 63 хяналтын камерийг шинээр суурилуулсан ба үүний 95,2 хувийг байгууллагын дотор талд, 4,8 хувийг гадна талд байршуулсан. Үүнд:<br>- Төвийн өргөтгөлийн хэсэгт 31ш,<br>- Төв байрны 1-4 давхрын шатны хонгилд 4 ширхэг,<br>- Төв байрны Туяа эмчилгээний тасаг, Яаралтай тусламжийн тасаг, Халдвар хяналт, сэргийлэлтийн алба (шинжилгээ сорьц авдаг хэсэг), Дүрс оношилгооны тасагт нийт 28 ширхэг<br>- Гүйцэтгэл-100%. |
| 8. | Байгууллагын санхүүгийн удирдлагыг үр ашигтай хэрэгжүүлж, өр, авлагагүй ажиллана. | - | Өр, авлагын хэмжээ | 2023 онд өр, авлагагүй ажилласан. | Өр, авлагагүй ажилласан байна. | Эхний 11 сарын байдлаар 20,9 тэрбум төгрөгийн авлага, 10,1 тэрбум төгрөгийн өглөгтэй байна.<br><br>Гүйцэтгэл-100% |

Хавдар судлалын үндэсний төв 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5 зорилтын хүрээнд нийт 53 үйл ажиллагааг төлөвлөсөн. Үүнээс 1 үйл ажиллагааг тооцох боломжгүй.

Гүйцэтгэлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд нийт 52 үйл ажиллагаанаас 44 нь 90-100 хувийн бүрэн гүйцэтгэлтэй, 8 үйл ажиллагаа нь хэрэгжих шатандаа, үр дүн гарч байгааг хяналт шинжилгээ, үнэлгээний баг дүгнэсэн. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний ерөнхий дүн 95.6 хувьтай байна.

**Тайланг хянасан:**

Эрүүл мэндийн сайд
(албан тушаал)

Тэмдэг

**Төсвийн Ерөнхийлөн захирагч:**

........................................ /С.Чинзориг/
(гарын үсэг)

**Тайлагнасан:**

ХСҮТ-ийн ерөнхий захирал
(албан тушаал)
Тэмдэг

**Төсвийн Шууд захирагч**

........................................ /Н.Эрдэнэхүү/
(гарын үсэг)

Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал
(албан тушаал)

........................................ /С.Хүрэлсүх/
(гарын үсэг)

Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал
(албан тушаал)

........................................ /Ц.Уранчимэг/
(гарын үсэг)

Нийгмийн эрүүл мэнд, төлөвлөлт, сургалтын албаны дарга
(албан тушаал)

........................................ /Ц.Бадамсүрэн/
(гарын үсэг)